



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/01/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим  
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Д.Мөнхтулга

Утас: 99031809 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЭНХСАЙХАН ТАНАА

2024-03-15 № 1/112  
танай 2024-02-15 -ны № 39 -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд дулааны станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд дулааны станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор Ховд дулааны станц ТӨХК нь 2023 онд 71,170.2 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж 70,328.1 Гкал дулааны эрчим хүчийг түгээж 55,927.1 Гкал дулааны эрчим хүчийг борлуулжээ.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар Ховд дулааны станц ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд борлуулалтын орлогыг 4,544.7 сая төгрөгөөр үйл ажиллагааны бусад орлогыг 182.2 сая төгрөгөөр, татаасыг 1090.9 сая төгрөг нийт 5,817.8 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр борлуулалтын орлого 4,995.5 сая, үйл ажиллагааны бусад орлого 4,995.5 сая, татаасыг 1,090.9 сая нийт 6,616.3 сая төгрөгөөр буюу 798.5 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	14,625,629.17	41,137,492.19
1.1.02	Дансны авлага	569,636,197.13	1,178,913,429.46
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	21,855,898.18	0.00
1.1.04	Бусад авлага	2,941,227.26	0.00
1.1.06	Бараа материал	866,662,713.64	1,123,100,055.95
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	21,345,000.00	745,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,497,066,665.38	2,343,895,977.60
1.2.01	Үндсэн хөрөнгө	10,892,294,100.75	10,702,487,576.40
1.2.02	Биет бус хөрөнгө	732,836,666.90	727,590,000.10
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,625,130,767.65	11,430,077,576.50
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,122,197,433.03</b>	<b>13,773,973,554.10</b>
2.1.1.01	Дансны өглөг	741,125,729.17	1,452,331,753.88
2.1.1.03	Татварын өр	205,445,071.92	359,184,146.47
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	169,019,611.78
2.1.1.05	Богино хугацаат зээл	80,000,000.00	0.00
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	60,000,000.00	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	30,228,972.50	5,230,351.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	14,526,834.49
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,116,799,773.59	2,000,292,697.62
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,116,799,773.59	2,000,292,697.62
2.3.01	Өмч: - төрийн	13,640,526,161.23	13,640,526,161.23
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,156,971,401.82	1,156,971,401.82
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	695,420,000.00	695,420,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-3,487,519,903.61	-3,719,236,706.57
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-231,716,802.96
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-3,487,519,903.61	-3,487,519,903.61
2.3.11	Эздийн өмчийн дүн	12,005,397,659.44	11,773,680,856.48
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>13,122,197,433.03</b>	<b>13,773,973,554.10</b>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	4,015,298,487.62	4,995,453,576.11
02	Борлуулалтын өртөг	3,811,174,671.15	5,770,682,448.07
03	Нийт ашиг( алдагдал)	204,123,816.47	-775,228,871.96
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	0.00	142,485.18
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	696,893,963.69	1,620,709,092.87
08.1	Орлогын дүн	696,893,963.69	1,620,851,578.05
09	Борлуулалт, маркетингийн зардал	138,012,928.45	304,860,731.45
10	Ерөнхий ба удирдлагын зардал	726,989,635.09	771,054,860.74
11	Санхүүгийн зардал	0.00	0.00

12	Бусад зардал	47,797,916.14	0.00
12.1	Зардлын дүн	912,800,479.68	1,075,915,592.19
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	-1,423,916.86
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг ( алдагдал)	0.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	0.00	-1,423,916.86
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	-11,782,699.52	-231,716,802.96
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
19.1	Хойшлогдсон татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-11,782,699.52	-231,716,802.96
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-11,782,699.52	-231,716,802.96
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	13,285,935,498.23	1,156,971,401.82	556,740,663.00	3,394,337,204.09	11,605,310,358.96
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-81,400,000.00	-81,400,000.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-11,782,699.52	-11,782,699.52
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	354,590,663.00	0.00	138,679,337.00	0.00	493,270,000.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	13,640,526,161.23	1,156,971,401.82	695,420,000.00	3,487,519,903.61	12,005,397,659.44
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-231,716,802.96	-231,716,802.96
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00

17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	13,640,526,161.23	1,156,971,401.82	695,420,000.00	3,719,236,706.57	-	11,773,680,856.48
----	---------------------------------	-------------------	------------------	----------------	------------------	---	-------------------

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,287,823,913.05	6,416,804,201.44
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,532,504,656.05	4,795,767,075.26
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,653,710.00	353,125.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	550,000,000.00	1,400,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	203,665,547.00	220,684,001.18
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,611,051,926.83	5,572,950,379.42
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,360,395,036.99	1,768,944,170.32
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	439,553,257.26	405,507,081.99
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	808,485,192.00	831,147,599.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	967,115,585.72	658,804,014.59
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	729,795,949.58	1,561,648,806.30
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	279,276,923.78	326,905,667.22
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,917,800.00	2,469,565.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	24,512,181.50	17,523,475.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	676,771,986.22	843,853,822.02
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	723,278,749.00	677,341,959.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	723,278,749.00	677,341,959.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-723,278,749.00	-677,341,959.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	342,300,000.00	0.00
3.1.1	Зээл авсан, ерийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	342,300,000.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	283,700,000.00	140,000,000.00
3.2.1	Зээл, ерийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	262,300,000.00	80,000,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөг төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	21,400,000.00	60,000,000.00
3.2.5	Бусад	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	58,600,000.00	-140,000,000.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	12,093,237.22	26,511,863.02
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,532,391.95	14,625,629.17
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,625,629.17	41,137,492.19

## 2.5 Аудит хийсэн эдийн засгийн зорилтот түвшний тайлан

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 он		Харьцуулалт өссөн/+, буурсан/-/				
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2022 оны гүйцэтгэлтэй		Төлөвлөгөөтэй		
						Тоо	хувь	Тоо	хувь	
1	1.1	Үйлдвэрлэсэн ДЭХ	Гкал	74,532.2	73,413.5	71,170.2	-	-	-	-
	1.2	Дотоод хэрэгцээний дулааны эрчим хүч	Гкал	1,003.7	1,170.3	842.2	161.5	16.1	328.1	28.0
			хувь	1.3	1.6	1.2	-	-	-	-
	1.3	Түгээсэн ДЭХ	Гкал	73,528.5	72,243.2	70,328.1	3,200.5	4.4	1,915.1	2.7
1.4	Шугамын алдагдал	Гкал	19,221.5	10,858.2	14,401.0	4,820.6	25.1	3,542.8	32.6	

1.5	Борлуулсан ДЭХ	Гкал	54,307.0	61,385.0	55,927.1	1,620.1	3.0	-	-
2	Нийт орлого	сая.төг	4,712.2	5,817.8	6,616.3	1,904.1	40.4	798.5	13.7
	Үүнээс:Борлуулалтын орлого	сая.төг	4,015.3	4,544.7	4,995.5	980.2	24.4	450.8	9.9
	Үйл ажиллагааны бусад орлого	сая.төг	378.7	182.2	529.9	151.2	39.9	347.7	190.8
	Санхүүжилт (татаас)	сая.төг	318.2	1,090.9	1,090.9	772.7	-	-	-
3	Нийт зардал	сая.төг	4,724.0	6,482.3	6,848.02	2,124.0	45.0	365.7	5.6
	Үүнээс:Үйл ажиллагааны зардал	сая.төг	4,676.2	6,482.3	6,846.6	2,170.4	46.4	364.3	5.6
	Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	47.8	-	1.4	-	-	1.4	-
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	-	-664.5	- 231.72	-	1,866.6	432.8	-
5	Цэвэр ашиг, алдагдал	сая.төг	11.8	-664.5	- 231.7	219.9	1,866.6	432.8	65.1
6	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	1.0	1.11	1.04	0.033	3.2	-	-
7	Нийт авлага	сая.төг	615.8	392.0	1,179.7	563.9	91.6	787.7	200.9
	Үүнээс: ЭХ-ний авлага	сая.төг	519.8	392.0	1,146.0	626.2	120.5	754.0	192.3
	Бусад авлага	сая.төг	96.0	-	33.7	-	-	33.7	-
8	Нийт өр төлбөр	сая.төг	1,116.8	842.0	2,000.3	883.5	79.1	1,158.3	137.6
	Үүнээс: Богино хугацаат	сая.төг	1,116.8	842.0	2,000.3	883.5	79.1	1,158.3	137.6
	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	-	-	-	-	-	-	-
9	Хөрөнгө оруулалт их засвар ТЗБАХ	сая.төг	791.8	509.79	490.4	-	-	-	-
10	Жишмэл түлшний хувийн зарцуулалт ДЭХ	кг.гкал	272.0	277.4	278.5	6.5	2.4	1.1	0.4
11	Нийт ажиллагсдын тоо	хүн	107.0	108.0	106.0	-	-	-	-
12	Нийт цалингийн сан	сая.төг	1,600.1	2,181.9	2,081.3	481.1	30.1	-	-

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 883,492.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч баталгаажуулав.

Залруулагдаагүй нийт 883,492.9 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 883,492.9 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрснээс алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 3.1.1. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Харилцагч байгууллагуудад дулааны эрчим хүч түгээсний орлогыг бүртгэхдээ и баримт цахим системд тухай бүрд нь нэхэмжлэх үүсгээгүй байгаа нь Төсвийн тухай

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийг хэрэгжүүлэн ажиллаж и баримтыг харилцагч тухай бүрд өгч ажиллах

### **5.1.2. Өглөг данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тус байгууллагын өр төлбөр нь материаллаг дүнтэй ТУЗ-аас баталсан дүнгээс ихээхэн өссөн өмнөх оноос 883,492.9 мянган төгрөгөөр өссөн байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг барагдуулах хуваарь гарган ажиллаж өр төлбөрийг бууруулан ажиллах

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Ховд дулааны станц ТӨХК	Харилцагч байгууллагуудад дулааны эрчим хүч түгээсний орлогыг бүртгэхдээ и баримт цахим системд тухай бүрд нь нэхэмжлэх үүсгээгүй	1	0					1	0		
<b>ДҮН</b>		<b>1</b>	<b>0</b>			-	-	<b>1</b>	<b>0</b>		

**2.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

*/мянган төгрөгөөр/*

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Ховд дулааны станц ТӨХК	Өр төлбөрийг барагдуулах хуваарь гарган ажиллаагүй	1	883,492.9					1	883,492.9
<b>ДҮН</b>		<b>1</b>	<b>883,492.9</b>					<b>1</b>	<b>883,492.9</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>
1	ТШЗ								
2	ТБОНӨ	1	1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			